



**БОГД БАНК**  
ХУВЬЦААТ КОМПАНИ

БОГД БАНКНЫ ТОС-ЫН АЖЛЫН ХЭСЭГ

2024

3-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

[www.bogdbank.com](http://www.bogdbank.com)



## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

Богд Банк нь байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагаа ухамсарласан, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг билээ. Бид өөрсдийн санхүүжүүлэх төсөлд ч энэхүү шалгуурыг тавьж, дэмжин ажилладаг бөгөөд уг зорилгын хүрээнд Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрт нэгдэн орж, 2015 оноос ТоС хөтөлбөрийн албан ёсны гишүүнээр элсэн орсон. Түүнээс хойш Богд банк өдөр тутмын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээндээ тогтвортой хөгжлийн зорилтуудыг үргэлж тусгаж ирсэн.



## НОГООН САНХҮҮЖИЛТ

Бид тайлант хугацаанд Богд банк нь ЖДҮ-г дэмжих зорилгынхоо хүрээнд Triple Jump/Gender Global Smart Fund-аас 5 сая ам. долларын санхүүжилтийг эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хүрээнд амжилттайгаар татлаа. Тус сангийн хөнгөлөлттэй зээлийг ЖДҮ эмэгтэй бизнес эрхлэгчдэд зээл бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан зээл, санхүүжилтийг дэмжихэд зарцуулах юм.



## ҮЛГЭРЛЭН МАНЛАЙЛАА

Богд банк нь Жижиг дунд бизнес эрхлэгч нараа дэмжин ажиллаж байна. Бид “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөжүүлж, өрсөлдөх чадвар, бүтээмжийг сайжруулж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тухайн бизнесийн үйл ажиллагаанд тохирсон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах сургалтыг 9 сарын 13-ны өдөр Богд товерийн 7 давхарт зохион байгуулагдлаа. Арга хэмжээнд **Жижиг, дунд үйлдвэрийн газар, Баянгол дүүргийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн холбоо ГҮТББ, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн BEST хөтөлбөр оролцлоо.** Богд банк ХК-ийн Байгууллагын банкны газрын дэд захирал Б.Билэгт, Хөгжлийн шийдэл ТББ-ын төлөөлөл болон холбогдох мэргэжилтнүүд оролцож, 50 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдав. Сургалтын үеэр “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээл”, Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй батлан даалттай төслийн зээл, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, харилцан санал солилцов.



## НӨӨЦИЙН ХЭМНЭЛТ

Бид нөөцийн хэмнэлтийн хүрээнд жил бүр шинэ санаа санаачилгыг гарган ажиллахыг зорин ажилладаг бөгөөд, цаасны хэрэглээ, хог хаягдлыг бууруулах Аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллахаар боллоо. Бид үүнийхээ хүрээнд 11 ш баттэрэй нийт 5.6 кг доктор авто сүлжээ хүлээлгэн өгөөд байна. Ашиглалтаас гарсан батарейгаа байгальд ээлтэй технологоор устгуулан, байгаль орчно хайрлан хамгаалах үүргээ биелүүлж байна.

